Нийт хөрөнгийн	109,721.1	133,830.7	24,109.6
Өр төлбөр	1,381.2	2,142.9	761.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	108,339.9	131,687.6	23,347.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	109,721.1	133,830.7	24,109.6

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

1. Тайлант хугацаанд 55,403.3 сая төгрөгийн мөнгөн орлого хүлээн авсан бөгөөд үйл ажиллагаанд 42,676.7 сая төгрөгийн мөнгөн зардал гарсан. Мөн 3,873.3 сая төгрөгийг хөрөнгө оруулалтанд зарцуулж, 25.5 сая төгрөгийг гадаад валютын ханшийн зөрүүнд төлснөөр мөнгөн хөрөнгө 8,827.8 сая төгрөгөөр өссөн байна.
2. Авлага данс 8,730.0 сая төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлаас шалтгаалан сургалтын төлбөрийг улирлаар төлсөн:
3. Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой эмнэлзүйн молекул оношилгооны төвд ковид илрүүлэх шинжилгээ авах болсон тул шаардлагатай урвалж бодисууд, тариур, шүлсний сав, сорьц хадгалах сав зэргийг худалдан авч нөөцлөснөөр бараа материалын үлдэгдэл 437.4 сая төгрөгөөр өссөн:
4. Тайлант жилд үндсэн хөрөнгө 72,749.6 сая төгрөг болж 6,123.5 сая төгрөгөөр өссөн. Энэ нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсвөөр бэлтгэсэн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил 3,872.4 сая төгрөг, улсын төсвөөс үнэ төлбөргүй шилжиж ирсэн 4,852.0 төгрөгийн хичээлийн барилга, буцалтгүй тусламжаар хүлээн авсан эмнэлгийн тоног төхөөрөмж 642.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь шалтгаалсан.
5. Тайлант жилд 214.9 сая төгрөгийн сургалтын төлбөрийн урьдчилгаа, эрдэм шинжилгээний ажлын урьдчилгаа 430.5 сая төгрөг орж ирсэн бөгөөд төв салбараас Уламжлалт эмнэлэгт зээлдүүлсэн 61.7 сая төгрөг, харилцагчаас 54.7 сая төгрөгийн урьдчилгаа орж ирснээр өглөг 761.8 сая төгрөгөөр өссөн.
6. Биет бус хөрөнгө нь тайлант жилийн хорогдлын 45.9 сая төгрөгийн зардлаар буурсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагаанаас 30,860.3 сая төгрөг, туслах үйл ажиллагаанаас 7,395.6 сая төгрөг, улсын төсвөөс 107.4 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,229.5 сая төгрөг, нийт 39,592.9 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөсөн.

Үүнээс урсгал зардалд 35,564.9 сая төгрөг, хөрөнгийн зардалд 5,717.0 сая төгрөг, тэтгэмжийн зардал 800.8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанаас 34,375.4 сая төгрөг, туслах үйл ажиллагаанаас 17,883.8 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,884.7 сая төгрөг, нийт 54,143.9 сая төгрөгний орлого төвлөрүүлжээ.

Үүнээс урсгал үйл ажиллагаанд 41,909.9 сая төгрөг, хөрөнгийн зардалд 2,824.3 сая төгрөг, тэтгэмжийн зардалд 581.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус сургууль нь нийт орлогын төлөвлөгөөг 14,658.5 сая төгрөг буюу 136.8 хувиар давуулан биелүүлсэн бол зардлыг 6,862.9.3 сая төгрөг буюу 19.6 хувиар хэтрүүлсэн байна.

Үүнд Сургалтын төлбөрийн орлогыг 3,515.1 сая төгрөгөөр, эмнэлгийн үйчилгээ болон бусад туслах үйлчилгээний орлогыг 10,488.1 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалаар

санхүүждэг үйлчилгээний орлогыг 655.2 сая төгрөгөөр тус тус давуулан биеллүүлсэн байна. Харин тайлангийн жилд төлөвлөөгүй резидентийн цалинг АШУҮИС-иар дамжуулан олгохоор Эрүүл мэндийн сайдын тушаал гарснаар цалингийн зардал 5,982.9 сая төгрөгөөр буюу 27.1 хувиар хэтэрсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2021 оны Санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын шилэн дансны цахим хуудсанд тайлант онд оруулбал зохих 578 мэдээллээс 76 мэдээллийг хугацаа хоцроосон, 176 мэдээллийг байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчил давтан гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул холбогдох ажилтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Баяр ёслол, тэмдэглэлт өдөр, урлагийн болон спортын наадам, уралдаан тэмцээнд 19.0 сая төгрөг, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалд 25.4 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.5-д “салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх”, 1.6. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулаагүй тул албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, зөрчлийг давтан гаргасан, баяр ёслол тэмдэглэлт өдөр, урлагийн болон спорт наадам тэмцээн зохион байгуулсан, зочин төлөөлөгч хүлээн авч бэлэг дурсгал өгсөн нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Засварын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсарын аудитаар эм зүйн сургуулийн лабораторид орон тооны ажилтан ажиллуулж орлогоо нэмэгдүүлэх, орлогуудыг зөв ангилалд бүртгэх, зардлыг зөв ангилан бүртгэх, санхүү эдийн засгийн газрын ажилтануудын үр чадварыг сайжруулах, нярав нягтлан бодогчийг хавсран ажиллуулахгүй байх зэрэг 5 зөвлөмж, орлого, зардлын ангилал болон тооцооллыг зөв хийж бүртгэлд тусгах, сургалтын төлбөрийн орлогыг зөв дүнгээр бүртгэх, төлбөрийн буцаалтыг зөв дансанд бүртгэх, түрээсийн орлогыг зөв тооцоолж бүртгэх зэрэг 6 залруулга өгсөн бөгөөд жилийн эцсийн аудитаар дахин хянахад 4 зөвлөмж, 6 залруулыг хэрэгжүүлсэн. Ажил хавсран гүйцэтгэх хориотой албан тушаалыг тусгаарлах 1 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байсан

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 245.8 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийг 75 хувь хэрэгжүүлсэн байна

Хүснэгт 4. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	4	245.8	3	66.9	75%
Нийт дүн	4	245.8	3	66.9	75%

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сургууль сургалтын төлбөрийн программтай, сургалтын төлбөрийн тооцоог оюутан нэг бүрээр хийдэг боловч энэхүү программ нь иж бүрэн биш, санхүүгийн программтай холбогдоогүй байна. Дараа жилийн аудитаар сургалтын төлбөрийн программ хангамжийг санхүүгийн программд холбогдсон эсэх, сургалтын төлбөрийн орлого болон авлагын бүртгэлд анхаарах

Сургуулийн харьяа эмнэлгүүд нь 2022 оноос үйл ажиллагааны программ хангамжтай болж байгаа бөгөөд эмнэлгийн орлого, зарлагын тооцоо нь хянагдаж байгаа эсэхэд анхаарах

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 565.7 сая төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 427.8 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 137.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 565.4 сая төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлаас 226.9 сая төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.3 Албан шаардлага

ЖМС-гаар тайлангийн жилд гэрээт ажилчдын (ХАС банкны данстай резидентийн) цалин, Удирдах зөвлөл, Эрдмийн Зөвлөлийн гишүүдийн урамшуулал, бараа материал, засварын зардал, тэтгэвэр тэтгэмж, урашуулалд 324.3 сая төгрөг, бэлэг дурсгалын зүйлс, хэлэлцүүлэг, семинар зохион байгуулсан зардалд 73.4 сая төгрөгийн зардал гаргасан бөгөөд дараа тооцоо хийхээр 30.1 сая төгрөгийн бэлэн мөнгө гаргуулан авч засварын болон бусад материал, ажил үйлчилгээ худалдан авсан боловч тооцоогоо дараа тооцооны тайлангаар хийгээгүй, хуулийн хүчин төгөлдөр баримт бүрдүүлээгүй (И баримтгүй) зарцуулсан.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 12 сарын 21-ны 276 тоот тушаалар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын журмын 2.5 Төсвийн байгууллага бэлэн мөнгөөр болон арилжааны банкны төлбөрийн картаар зарлага хийхдээ зарцуулалтын эрхийн хүрээнд

зөвшөөрөгдсөн төсвийн хуваарийн дагуу гүйцэтгэх бөгөөд Төрийн сангаас тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн баталж өгсөн жижиг мөнгөн сангийн /цаашид “ЖМС” гэх/ хязгаарыг дагаж мөрдөнө, 2.7 Мөнгөн кассын санхүүгийн баримт нь засваргүй, үнэн зөв хөтлөгдөж, баримтын бүрдлийг хангасан байх ба зарлагын төлбөр гүйцэтгэх эрхийг олгосон албан ёсны шийдвэрт үндэслэгдэн цохолт хийгдсэн байна гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.7 Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон жижиг мөнгөн сангийн журмыг зөрчсөн тул зөрчлийг давтан гаргахгүй байх Албан шаардлага өгөх

Сургуулийн захирлын 2021 оны А/240 дүгээр тушаалаар хөрөнгийн тооллого хийх комисс томилсон боловч комиссын гишүүд тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, зөвхөн хариуцсан нягтлан бодогч, няравууд тоолж, тооцоог бодон, тооллогын тайлан, илтгэх хуудас бэлтгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна, 12.2.1 жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө заавал хөрөнгийн тооллогыг хийх гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох хуульд зааснаар жилийн эцсийн тооллогыг санхүүгийн тайлан гарахаас өмнө хийх бөгөөд байгууллагын урдирдлагаар гарын үсэг зурж баталгаажсан байх. Зөрчлийг давтахгүй байх. Албан шаардлага өгөх

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг эмнэлгийн орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сургуулийн сургалтыг түшиглэсэн харьяа 4 эмнэлэг нь үйл ажиллагааны программ хангамжгүй, орлогыг бэлнээр төвлөрүүлдэг, нягтлан бодох бүртгэлд тавих хяналт сул байна.

Өгсөн зөвлөмж

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байгаа эмнэлгүүдийн үйл ажиллагаанд тохирсон программ хангамжтай болох, программ хангамжаар үйлчилгээний орлого болон зардлыг үнэн зөв тооцоолж бүртгэж байх

2. Захиргааны болон хангамжийн албаны бусад зардлыг зөв ангиалан бүртгэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт

Захиргааны болон хангамжийн албаны бусад зардалд 4.6 сая төгрөгийн автомашины засвар, 71.2 сая төгрөгийн хамгаалалтын зардал болон бэлэг дурсгалын зардалыг бүртгэсэн байна.

Өгсөн зөвлөмж

Захиргааны болон хангамжийн зардалд бүртгэх зүйлсийн талаар бүртгэлийн бодлогодоо тусгах, засварын болон хамгаалалт, бэлэг дурсгалын зардлыг зөв ангилалд бүртгэж байх.

3. Хичээл практикийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт

Тайлант жилд хичээл практикийн зардалд 10.0 сая төгрөгийн хичээлийн шинэ жилийн нээлтийн зардал, 6.1 сая төгрөгийн эрүүл мэндийн байгууллагын 100 жилийн ойд зориулсан зардал, 10.2 сая төгрөгийн лаборатори нүүлгэх зардал, 14.1 сая төгрөгийн хэлэлцүүлгийн зардал, 5.0 сая төгрөгийн шинэ жил тэмдэглэсэн зардал болон 16.1 сая төгрөгийн спортын заалны засварын зардал зэргийг тус тус бүртгэсэн байна.

Өгсөн зөвлөмж

Сургуулийн хэмжээгээр хичээл практикийн зардалд ямар зардал оруулах, энэ зардлыг бүртгэлд яаж тусгах талаар нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо тусгах, зардлаа зөв ангилан бүртгэх

4. Сургуулийн дэргэдэх гарааны компанитай холбоотой асуудал

Илрүүлэлт

Сургуулийн захирлын тушаалаар Гарааны Си фор Эй нэртэй компани байгуулж 2021 оны 6 сарын 25-нд Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани хэлбэрээр зохион байгуулагдан улсын бүртгэлд бүртгүүлсэн байна. Компанийн үйл ажиллагааны чиглэл нь Шүлсэнд SARS-COV-2 шууд аргаар бодит хугацааны ПГУ-ын оношлуур бүтээх, хэрэглээнд нэвтрүүлэх болно. Энэ гарааны компани нь 5 үүсгэн байгуулагч буюу хувьцаа эзэмшигчидтэй бөгөөд хувьцаа эзэмшигч, үүсгэн байгуулагчийн бүрэлдэхүүнд АШУҮИС-аас ямар ч төлөөлөл байхгүй, компанийн дүрэмд сургуулийн зүгээс хяналтыг яаж тавих, удирдах тухай заалт байхгүй байна.

Өгсөн зөвлөмж

Сургуулийн дэргэдэх гарааны компани байгуулж байгаа бол тус компанийг хянах, удирдах эрх, үүргээ тодорхой болгох

5. Санхүү эдийн засгийн албаны ажилтануудтай холбоотой асуудал

Илрүүлэлт

Төрийн өмчтэй аж ахуйн нэгж болон төсөвт байгууллагын ерөнхий нягтлан бодогчийн шалгуур, шаардлага хангаагүй ажилтаныг ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалд томилон ажиллуулж байна. Мөн Төв салбарын бэлэн мөнгөний нярав, салбарын нягтлан бодогчийн үүргийг 3 сарын турш хавсруулан гүйцэтгүүлсэн байна.

Өгсөн зөвлөмж

Мэргэжлийн шалгуур, шаардлага хангасан ажилтаныг ерөнхий нягтлан бодогчоор ажиллуулах, нярав нягтлан бодогчийн ажлыг хавсран гүйцэтгүүлэхгүй байх

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Д/ Д	Байгуул лагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
			Санхүүгийн тайлангийн аудитаар													
1	АШУУИС	АХГ- 2022/08/ НА-СТА- ТӨА	ЖМС-гаар тайлангийн жилд нийтдээ 593,5 сая төгрөгийн зарцуулалт гаргаснаас 427.8 сая төгрөгийн дараахь зардлуудыг гаргасан байна. Үүнд: гэрээт ажилчдын (ХАС банкны данстай резидентийн) цалин, Удирдах зөвлөл, Эрдмийн Зөвлөлийн гишүүдийн урамшуулал, бараа материал, засварын зардал, тэтгэвэр тэтгэмж, урашуулалд 324.3 сая төгрөг, бэлэг дурсгалын зүйлс, хэлэлцүүлэг, семинар зохион байгуулсан зардалд 73.4 сая төгрөг, дараа тооцоо хийхээр 30.1 сая төгрөгийн бэлэн мөнгө гаргуулан авч засварын болон бусад материал, ажил үйлчилгээ худалдан авсан боловч тооцоогоо дараа тооцооны тайлангаар хийгээгүй, хуулийн хүчин төгөлдөр баримтын бүрдэлгүй (И баримтгүй) зарцуулсан.	Нягтлан бодох бүртгэлийн хууль болон ЖМС-ийн журмыг зөрчсөн тул зөрчлийг давтан гаргахгүй байх Албан шаардлага өгөх	1	427,818.1					1	42,7818.1				

**Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит**

2	АШУУИС		Сургуулийн захирлын 2021 оны А/240 дүгээр тушаалаар хөрөнгийн тооллого хийх комисс томилсон боловч комиссын гишүүд тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, зөвхөн хариуцсан нягтлан бодогч, няравууд тоолж, тооцоог бодон, тооллогын тайлан, илтгэх хуудас бэлтгэсэн байна.	Нягтлан бодох хуульд зааснаар жилийн эцсийн тооллогыг санхүүгийн тайлан гарахаас өмнө хийх бөгөөд байгууллагын урдирдлагаар гарын үсэг зурж баталгаажсан байх ёстой. Зөрчлийг давтан гаргахгүй байх. Албан шаардлага өгөх	1	1				1	-					
3	АШУУИС		Төрийн өмчтэй аж ахуйн нэгж болон төсөвт байгууллагын ерөнхий нягтлан бодогчийн шалгуур, шаардлага хангаагүй ажилтаныг ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалд томилон ажиллуулж байна. Мөн Төв салбарын бэлэн мөнгөний нярав болон салбарын нягтлан бодогчийн үүргийг 3 сарын турш хавсруулан гүйцэтгүүлсэн байна.	Мэргэжлийн зохих шалгуур шаардлага хангасан ажилтаныг ерөнхий нягтлан бодогчоор ажиллуулах, нярав нягтлан бодогчийн ажлыг хавсран гүйцэтгүүлэхгүй байх	1	-					-				1	
4	АШУУИС		АШУУИС-ийн сургалтыг түшиглэсэн харьяа 4 эмнэлэг нь үйл ажиллагааны программ хангамжгүй, орлогыг бэлнээр төвлөрүүлдэг, нягтлан бодох бүртгэлд тавих хяналт сул байна.	Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байгаа эмнэлгүүдийн үйл ажиллагаанд тохирсон программ хангамжтай болох, программ хангамжаар үйлчилгээний орлого болон зардлыг үнэн зөв тооцоолж бүртгэж байх	1	-									1	-
5	АШУУИС		Захиргааны болон хангамжийн албаны бусад зардалд 4.6 сая төгрөгийн автомашины засвар, 71.2 сая төгрөгийн хамгаалалтын	Захиргааны болон хангамжийн зардалд бүртгэх зүйлсийн талаар бүртгэлийн	2	75,833.1									2	75,833.1

**Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит**

			зардал болон бэлэг дурсгалын зардалыг бүртгэсэн байна.	бодлогодоо тусгах, засварын болон хамгаалалт, бэлэг дурсгалын зардлыг зөв ангилалд бүртгэж байх.											
6	АШУУИС		Тайлант жилд хичээл практикийн зардалд 10.0 сая төгрөгийн хичээлийн шинэ жилийн нээлтийн зардал, 6.1 сая төгрөгийн эрүүл мэндийн байгууллагын 100 жилийн ойд зориулсан зардал, 10.2 сая төгрөгийн лаборатори нүүлгэх зардал, 14.1 сая төгрөгийн хэлэлцүүлгийн зардал, 5.0 сая төгрөгийн шинэ жил тэмдэглэсэн зардал болон 16.1 сая төгрөгийн спортын заалны ОО-ын өрөөний засварын зардал зэрэг зардлыг тус тус бүртгэсэн байна.	Сургуулийн хэмжээгээр хичээл практикийн зардалд ямар зардал оруулах, энэ зардлыг бүртгэлд яаж тусгах талаар нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо тусгах, зардлаа зөв ангилан бүртгэх	6	62,045.8								6	62,045.8
7	АШУУИС		Сургуулийн захирлын тушаалаар Гарааны Си фор Эй нэртэй компани байгуулж 2021 оны 6 сарын 25-нд Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани хэлбэрээр зохион байгуулагдан улсын бүртгэлд бүртгүүлсэн байна. Компанийн үйл ажиллагааны чиглэл нь Шүлсэнд SARS-COV-2 шууд аргаар бодит хугацааны ПГУ-ын оношлуур бүтээх, хэрэглээнд нэвтрүүлэх болно. Энэ гарааны компани нь 5 үүсгэн байгуулагч буюу хувьцаа эзэмшигчидтэй бөгөөд хувьцаа эзэмшигч, үүсгэн байгуулагчийн бүрэлдэхүүнд АШУУИС-аас ямар ч төлөөлөл байхгүй, компанийн дүрэмд сургуулийн зүгээс хяналтыг яаж тавих, удирдах тухай заалт байхгүй байна.	Сургуулийн дэргэдэх гарааны компани байгуулж байгаа бол тус компанийг хянах, удирдах эрх, үүргээ тодорхой болгох	1									1	-
			Нийцлийн аудитаар												

**Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит**

1	АШУУИС		Баяр ёслол, тэмдэглэлт өдөр, урлагийн болон спортын наадам, уралдаан тэмцээнд 19.0 сая төгрөг, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалд 25.4 сая төгрөг тус тус зарцуулсан байна.	Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулаагүй тул Албан шаардлага өгөх	1											
2	АШУУИС		Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлийн дагуу нийт 609 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэх, байршуулсан мэдээллийн үнэн зөв эсэхийг тулган шалгахад 326 мэдээллийг хугацаанд нь, 76 мэдээллийг хугацаа хоцроосон, 176 мэдээллийг байршуулаагүй зөрчилтэй байна.	Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлэх	252	-					252	-				
			Нийт дүн			565,697.0						427,818.1				137,878.9



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 594/А0150058
АХС-2022/08/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Сургуулийн захирлын 2021 оны А/240 дүгээр тушаалаар хөрөнгийн тооллого хийх комисс томилсон боловч комиссын гишүүд тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, зөвхөн хариуцсан нягтлан бодогч, нярвууд тоолж, тооцоог бодон, тооллогын тайлан, илтгэх хуудас бэлтгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө заавал хөрөнгийн тооллогыг хийх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Нягтлан бодох хуульд зааснаар жилийн эцсийн тооллогыг санхүүгийн тайлан гарахаас өмнө хийх бөгөөд байгууллагын удирдлагын гарын үсэг зурж баталгаажуулсан байх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн гүйцэтгэх захирал Н.Хүрэлбаатар, Санхүү, эдийн засгийн газрын дарга Ц.Ишдорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

НАЙДВАР-ОД АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Ж.ЭНХЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-269.Docx

0001031542



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 598/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/08/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Баяр ёслол, тэмдэглэлт өдөр, урлагийн болон спортын наадам, уралдаан тэмцээнд 19,000,000.00 төгрөг, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалд 25,422,986.00 төгрөг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 "зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зардлыг гаргахгүй байх", 1.6. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулдаг байх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн гүйцэтгэх захирал Н.Хүрэлбаатар, Санхүү, эдийн засгийн газрын дарга Ц.Ишдорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР  Б.СЭРЖМЯДАГ
НАЙДВАР-ОД АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР  Ж.ЭНХЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230 9019120396

Z:\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-271.Docx

0001031547



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15-д № 599/АУ150058
АХГ - 2022/08/НА - СТА - ТӨА

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын шилэн дансны цахим хуудсанд тайлант онд оруулбал зохих 578 мэдээллээс 76 мэдээллийг хугацаа хоцроосон, 176 мэдээллийг байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчил давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.1.3 "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор мэдээлэл байршуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дүгээр зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын 4.2.2 "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан холбогдох ажилтанд хариуцлага тооцох, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний Аудитын Газарт ирүүлэхийг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн гүйцэтгэх захирал Н.Хүрэлбаатарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР **Б.НАРАНЧИМЭГ**
АУДИТЫН МЕНЕЖЕР **Б.СЭРЖМЯДАГ**
НАЙДВАР ОД АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР **Ж.ЭНХЧИМЭГ**

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

0001081536 0010120396 10.10.2018 Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-268.Docx

0001081536



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 600/AU150058,
АХГ-2022/08/НА-СТА-ТӨА
Зөрчил арилгуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Жижиг мөнгөн сангаар тайлангийн жилд нийтдээ 593,513,709.96 төгрөгийн зарцуулалт гаргаснаас 427,818,100.00 төгрөгийн дараах зардлуудыг гаргасан байна. Үүнд: гэрээт ажилчдын (ХАС банканд данстай резидентийн) цалин, Удирдах зөвлөл, Эрдмийн Зөвлөлийн гишүүдийн урамшуулал, бараа материал, засварын зардал, тэтгэвэр тэтгэмж, урамшуулалд 324,353,239.00 төгрөг, бэлэг дурсгалын зүйлс, хэлэлцүүлэг, семинар зохион байгуулсан зардалд 73,374,711.00 төгрөгийн зардал гаргасан бөгөөд дараа тооцоо хийхээр 30,090,150.00 төгрөгийн бэлэн мөнгө гаргуулан авч засварын болон бусад материал, ажил, үйлчилгээ худалдан авсан боловч тооцоогоо дараа тооцооны тайлангаар хийгээгүй, хуулийн хүчин төгөлдөр баримт бүрдүүлээгүй (И баримтгүй) зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Мөн Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын журмын 2.5 “Төсвийн байгууллага бэлэн мөнгөөр болон арилжааны банкны төлбөрийн картаар зарлага хийхдээ зарцуулалтын эрхийн хүрээнд зөвшөөрөгдсөн төсвийн хуваарийн дагуу гүйцэтгэх бөгөөд Төрийн сангаас тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн баталж өгсөн жижиг мөнгөн сангийн /цаашид “ЖМС” гэх/ хязгаарыг дагаж мөрдөнө”, 2.7 “Мөнгөн кассын санхүүгийн баримт нь засваргүй, үнэн зөв хөтлөгдөж, баримтын бүрдлийг хангасан байх ба зарлагын төлбөр гүйцэтгэх эрхийг олгосон албан ёсны шийдвэрт үндэслэгдэн цохолт хийгдсэн байна” гэсэн заалтуудыг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”,

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Нягтлан бодох бүртгэлийн хууль болон Сангийн сайдын баталсан Жижиг мөнгөн сангийн журмыг мөрдөж ажиллах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн гүйцэтгэх захирал Н.Хүрэлбаатар, Санхүү, эдийн засгийн газрын дарга Ц.Ишдорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

НАЙДВАР-ОД АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР



[illegible]

[illegible]

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of numerous horizontal rows, each defined by two parallel dotted lines. The rows are evenly spaced and extend across the entire width of the page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.